

ИХ ДЭЭД СУРГУУЛИЙН БАГШ НАРЫГ АНУ-Д СУРГАХ ТЭТГЭЛЭГ-2011

Өргөдөл хүлээж авах эцсийн хугацаа: 2010 оны 3-р сарын 10

http://www.soros.org/initiatives/scholarship/focus_areas/facult_scholarships/guidelines

АНУ дахь Нээлттэй Нийгэм Хүрээлэнгээс Азербайжан, Армен, Гүрж, Казахстан, Киргизстан, Молдав, Монгол, Тажикистан, Узбекистан улсын их дээд сургуулийн нийгэм, хүмүүнлэгийн ухааны багш нарын дунд АНУ-д тэтгэлгээр суралцах хөтөлбөрийг зарлаж байна. Тус хөтөлбөрийн зорилго нь дээрх орнуудын нийгмийн ухааны тэнхмийг хөгжүүлэх, багш нарын заах аргыг сайжруулах, судалгааны ажил хийхийг нь дэмжих явдал юм.

Эрдмийн зэрэг олгохгүй энэхүү хөтөлбөрт шалгарсан багш нар АНУ-ын их дээд сургуульд нэг семестрийн хугацаатайгаар сурч ажиллана. Энэ хугацаанд олж авсан мэдлэг чадвараа өөрийн сургуульдаа хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ. Шалгарсан хүмүүс 2011 оны 1-р сараас эхлэн энэхүү хөтөлбөрт хамрагдах боломжтой.

Тавигдах шаардлага:

- Америк судлал, Урлагийн түүх, Соёлын антропологи, Түүх, Хууль, Философи, Улс төр, Шашин судлал болон Социологийн хичээлийг их дээд сургуульд өдрөөр заадаг багш байх;
- Их дээд сургуулийг онцсайн дүнтэй төгссөн байх;
- Бичгийн болон ярианы Англи хэлийг сайн эзэмшсэн байх;
- Магадлан итгэмжлэгдсэн их дээд сургуулийг төгссөн байх /наад зах нь 5 жил сурч мэргэжлийн ахисан шатны зэрэг авсан байх/;
- 2011 оны 1-р сараас 2012 оны 5-р сар хүртэл тус хөтөлбөрт оролцох боломжтой байх;
- 2011 оны 1-5-р сар, 2012 оны 1-5-р сард сургуулиас нь чөлөө олгохыг зөвшөөрсөн захирал, дэд захирал, тэнхмийн эрхлэгчийн хэн нэгний нь тодорхойлолт авсан байх;
- Монгол улсын оршин суугч байх

Бүрдүүлэх зүйлс

1. Өргөдлийн маягтыг бүрэн бөглөж өгнө /Өргөдлийн маягтыг www.earcmn.org хаягаар орж авна уу/
2. 2 болон түүнээс дээш хүний тодорхойлолт /битүүмжилсэн байх/
3. Зорилго тодорхойлсон захидал буюу эссээ /асуултыг өргөдлийн маягтад заасан байгаа/
4. Өөрийн сургуулийн захиргаанаас дэмжсэн тодорхойлолт
5. Дээд боловсролын бүх диплом болон дүнгийн жагсаалтын хуулбар /нотариатаар баталгаажуулсан байх/
6. Дээд боловсролын бүх диплом болон дүнгийн жагсаалтын албан ёсны орчуулга /орчуулгын товчоогоор баталгаажуулсан байх/
7. Товч намтар буюу CV
8. Гадаад паспортын зурагтай хуудасны хуулбар

Өргөдлийг хүлээн авах эцсийн хугацаа: 2010 оны 3 сарын 10

Өргөдлийн болон бүх хавсралт материалуудын эх хувийг нэг хуулбарын хамт дээрх дарааллын дагуу 2010 оны 3 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ. Хугацаа хэтэрсэн болон дутуу бүрдүүлсэн материалыг хүлээж авахгүй болохыг анхаарна уу.

Дэлгэрэнгүй мэдээлэл болон өргөдлийн материал бөглөх талаар зөвлөгөөг Баасан гариг бүрийн 16.00 цагаа БЗМТ дээр өгч байгаа тул өргөнөөр хүрэлцэн ирнэ үү.

Холбоо барих хаяг: Э.Ариунаа, тэтгэлэгт хөтөлбөрийн зохицуулагч
Боловсролын Зөвлөгөө Мэдээллийн Төв, Утас: 976-11-319016,
Э-шуудан: ariunaa@earcmn.org, Вэб хуудас: <http://www.earcmn.org>